

**Аудитын код: САГ-2018/4/СТА-ТТЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663      Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261885      Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Ахлах аудитор Ц.Хосжаргал

Утас: 261628      Цахим хаяг: [khosjargalts@audit.gov.mn](mailto:khosjargalts@audit.gov.mn)

Аудитор Б.Уянга


Утас: 261628      Цахим хаяг: [uyangab@audit.gov.mn](mailto:uyangab@audit.gov.mn)

Улаанбаатар хот



**АГУУЛГА**

Аудитын гэрчилгээ .....	0
1. Аудитын тайлан .....	1
1.1 Оршил .....	1
1.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл .....	1
1.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа .....	2
1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	2
1.5 Дотоод хяналт .....	3
1.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
1.7 Шилэн дансны мэдээлэл .....	4
1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	4
1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	4
1.9.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн залруулга .....	4
1.9.2 Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд илэрсэн зөрчил .....	5
1.9.3 Улсын төсвийн орлого хяналтын газрын санхүүгийн тайланд илэрсэн зөрчил .....	6
1.9.4 Дотоод аудит .....	7
1.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
1.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	7
1.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	7
1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
1.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
1.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	8
1.16 Аудитын үр өгөөжийн бүртгэл .....	8
2.1. Мөнгөн хөрөнгө .....	10
2.2. Мөнгөн хөрөнгө .....	10
2.3. Бараа материал.....	10
2.4. Бараа материал.....	11
2.5. Дотоод аудит .....	11
3. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	12
3.1. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	12
3.2. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	13
3.3. Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	14
3.4. Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
3.5. Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16





## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2018.03.23 № 01/200  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЗАНДАНБАТ  
ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Татварын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Татварын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Татварын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Khireg\Tawsan\_bichig\2018\03\23\01\020.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

071408

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

## 1. АУДИТЫН ТАЙЛАН

### 1.1 ОРШИЛ

Татварын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Татварын ерөнхий газрын дарга Д.Занданбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн болон өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 1.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл


Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Татварын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Татварын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Аудитыг 2018 оны 3 дугаар сарын 05-наас 2018 оны 3 дугаар сарын 22-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, аудитор Б.Уянга нар хариуцаж хэрэгжүүлэв.

Татварын ерөнхий газрын дарга 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2018 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 03/785 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

### 1.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ татварын алба, татвар төлөгч шударгаар биелүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд орших ба төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх үндсэн зарчмуудыг баримтлан ажиллаж байна.

Татварын ерөнхий газар нь дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах;
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх.

Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.


### 1.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 - 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Татварын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Татварын ерөнхий газраас тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 12 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 46 горим, сорил гүйцэтгэв.



Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Татварын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2013 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дараах асуудлыг дэлгэрэнгүй тусгах нь зүйтэй. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал;
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого.

Татварын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Татварын ерөнхий газар санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа 33 байгууллагын санхүүгийн тайлан “Э-тайлан” програм хангамж ашиглан нэгтгэсэн байна.

## 1.5 Дотоод хяналт


Татварын ерөнхий газрын даргын 2017 оны А/51 дүгээр тушаалаар дотоод аудитын газар “Татварын албаны үйл ажиллагаанд дотоод аудит хийх заавар” батлуулж, 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Татварын хууль, тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх тогтолцоог боловсронгуй болгох, дотоод аудитыг бэхжүүлэх” гэсэн байгууллагын үйл ажиллагааны 4 стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх 11 ажил хийхээр төлөвлөгөө батлуулсан байна. Төлөвлөгөөний дагуу харьяа байгууллагуудын татварын орлого бүрдүүлэлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаа болон үнэт цаас, тооцоот баримт, маягтын ашиглалтын байдалд хийсэн дотоод аудитаар “Их хэмжээний сайжруулалт хэрэгтэй” гэж үнэлэгдсэн байна.

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

## 1.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Татварын ерөнхий газрын 2017 оны урсгал болон хөрөнгө оруулалтын зардалд улсын төсвөөс 30,077.4 сая төгрөг, өөрийн орлогоос 2,066.0 сая төгрөг нийт 32,143.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

Улсын төсвөөс 30,053.1 сая төгрөгийн санхүүжилт олгогдож батлагдсанаас 24.3 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.



Өөрийн орлогоос 3,178.2 сая төгрөг бүрдүүлж, төлөвлөгөөг 1,106.0 сая төгрөг буюу 53.4 хувиар давуулсан байна. Сангийн сайдын “Улсын төсвийн байгууллагын 2017 оны үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах тухай” 2017 оны 372 дугаар тушаалаар 1,106.0 сая төгрөгөөр зарцуулах эрх олгож, гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан байна.

Тайлант онд 31,850.2 сая төгрөг зарцуулж, 99.1 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд санхүүжилтийн үлдэгдэл 269.0 сая төгрөгийг Төв төрийн сангийн дансанд төвлөрүүлжээ.

2016 оны НӨАТ-ын 20 хүртэлх хувийн буцаан олголт болон урамшууллын 40,975.5 сая төгрөгийн санхүүжилтийн орлого орж, гүйцэтгэлээр 40,275.6 сая төгрөгийг олгож, үлдэгдэл 699.9 сая төгрөгийг төв төрийн санд төвлөрүүлсэн байна.

### 1.7 Шилэн дансны мэдээлэл

Татварын ерөнхий газар нь “shilendans.gov.mn” цахим хуудсанд дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна. Үүнд:

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
3. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)
4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил, үйлчилгээний гүйлгээ (Тухай бүр)
5. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)

### 1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу тохиолдох магадлалтай дансанд хамаарах уламжлалт болон хяналтын эрсдэлийг агуулж байж болзошгүй гэж урьдчилан тооцоолсон бөгөөд батламж мэдэгдлүүдийн хүрээнд 12 аудитын чиглэлд нийт 46 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэлээ.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан маягтын дагуу данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

### 1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Татварын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрснийг доорх байдлаар шийдвэрлэсэн болно.

#### Санхүүгийн нэгтгэсэн тайланд илэрсэн зөрчил

##### 1.9.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн залруулга





Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан *“Төсвийн ерөнхийлөн захирагч болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 4.2. “Нэгтгэлийг дараах үе шатаар хийнэ: Үүнд 4.2.1 Мөр мөрөөр нэгтгэх зоримыг баримтална. Байгууллага санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч орлого, зардал зэрэг үзүүлэлтүүдийг мөр мөрөөр нь нэмэх байдлаар хяналт тавигч байгууллагын болон түүний хяналтад байгаа байгууллагын санхүүгийн тайлангуудыг нэгтгэнэ...”* гэсэн заалтыг зөрчиж мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагыг 16.1 сая төгрөгөөр дутуу, төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэхдээ харьяа зарим байгууллагын төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг тохируулаагүй дүнгээр буюу 20.5 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийлгэв.

Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан *“Төсвийн ерөнхийлөн захирагч болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 4.2. “Нэгтгэлийг дараах үе шатаар хийнэ: Үүнд 4.2.2 Давхардсан ажил гүйлгээг устгах бичилтийг бүрэн хийнэ. Үүнд нэгтгэлд хамрагдсан байгууллага хоорондын авлага, өглөгийн дансны үлдэгдэл, орлого болон зардлын ажил гүйлгээ гэх мэт давхардсан гүйлгээг бүрэн устгана.”* гэсэн заалтыг зөрчиж үр дүнгийн тайланд харьяа байгууллагууд хооронд шилжүүлсэн 2.3 сая төгрөгийн хөрөнгө, Татварын ерөнхий газар болон харьяа байгууллагууд хооронд шилжүүлсэн өөрийн орлогыг 93.1 сая төгрөг, дээд шатны захирагчаас нэмэлт санхүүжилтээр олгосон 48.5 сая төгрөгийн орлого, зарлагын устгах бичилтийг дутуу хийсэн байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийлгэв.

## **Түүврийн байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд илэрсэн зөрчил**

### **1.9.2 Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд илэрсэн зөрчил**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4. *“Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:.... 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;”* гэсэн заалтыг зөрчиж санхүүгийн байдлын тайланд харилцах дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд 501.1 сая төгрөгөөр дутуу тусгасан байна.


Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

НББОУС-38-д *“Хөгжүүлэлтийн үед гарсан зардлыг дараах шалгуурыг хангаж байвал биет бус хөрөнгө гэж үзнэ. Бусад тохиолдолд тайлант үеийн зардлаар бүртгэнэ. а) Биет бус хөрөнгө нь иж бүрдэл болсон, ашиглах эсвэл борлуулах боломжтой. б) Байгууллага биет бус хөрөнгийн иж бүрдэл болгож ашиглах эсвэл борлуулах үнэхээр эрмэлзэлтэй. с) Байгууллага биет бус хөрөнгийг ашиглах эсвэл борлуулах чадвартай. d) Хөгжүүлэлтийн үеийг цааш нь дуусгах биет бус хөрөнгийг ашиглах болон борлуулах техникийн санхүүгийн бусад нөөцүүд байвал;”* гэсэн заалтыг зөрчиж нэмэгдсэн өртгийн албан татварын нэгдсэн системийн програм хангамжийн хөгжүүлэлтэд 2013-2016 онд зарцуулсан 2,032.4 сая төгрөгийн хөрөнгийг биет бус хөрөнгөөр тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т *“Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.”* гэсэн заалтыг зөрчиж урьдчилж төлсөн үйлчилгээний болон зардлын 130.9 сая төгрөгийн төлбөрийг тайлант оны зардалд тусгасан.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв.



Анхан шатны баримтын бүрдэлгүй 8.1 сая, 2016 оны анхан шатны баримтаар 0.9 сая төгрөгийн ажил гүйлгээг данс бүртгэлд тусгасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангах, тайлант оны ажил гүйлгээг бүртгэж байх зөвлөмж өгөв.

Харилцах данснаас шилжүүлсэн 15.7 сая төгрөгийн бэлэн мөнгийг тогтоосон хязгаараас хэтрүүлэн авч зарцуулсан байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаал "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 6.3-т "Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ... нийт дүн 300.0 мянган төгрөгөөс .... хэтрэхгүй байна." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг хариуцсан ажилдаа дагаж мөрдөх зөвлөмж өгөв.

Үнэт цаасны тооцоог анхан шатны баримттай тулгахад 0.3 сая төгрөгийн зарцуулалтын анхан шатны баримт байхгүй, зарцуулалтын баримтад үнэт цаасны серийн дугаар давхардсан, үнэт цаасны тооллого тооцоог сар бүр хийдэггүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Тооллого тооцоог цаг тухайд нь хийж байх зөвлөмж өгөв.

Уралдаан тэмцээний зардал, ажлын хэсгийн хоолны зардалд төсвөөс 12.6 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заасантай нийцэхгүй байна.


Шийдвэрлэсэн: Төсвийг үр ашигтай зарцуулж байх албан шаардлага өгөв.

Татварын өр төлбөрт 2000 оноос өмнө хураагдсан 43.1 сая төгрөгийн өртөгтэй Баянгол дүүрэгт байрлах 108.8 м2 нийтийн байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ байхгүй, тус байранд 2012 оноос ТЕГ-ын жолооч, УТОХГ-ын татварын улсын ахлах байцаагч нар амьдарч байгаа боловч түрээсийн гэрээг 2013 оноос хойш сунгаагүй, түрээсийн төлбөр аваагүй байгаа нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Түрээсийн гэрээ хийж орлого бүрдүүлж байх албан шаардлага өгөв.

### 1.9.3 Улсын төсвийн орлого хяналтын газрын санхүүгийн тайланд илэрсэн зөрчил

Жилийн эцэст тооллого явуулахдаа бараа материалын үлдэгдлийг тоолж, баталгаажуулаагүй, тооллогын комисс тооллогын бүртгэлийг баталгаажуулаагүй, илтгэх хуудас бэлтгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: ... 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/; ...; 72 дугаар зүйлийн 4.-т "Тооллогын комисс дараах үеийн зах зээлийн хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих, 4/ комиссын хурлаар



тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Хуулийн дагуу эд хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай гүйцэтгэх зөвлөмж өгөв.

#### 1.9.4 Дотоод аудит

"Дүрэм батлах тухай" Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дараах хүрээнд хийнэ, 5.1.3-д "төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал," гэж заасныг зөрчсөн байна. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,887.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,532.5 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 20.0 сая төгрөгийн зөрчилд акт, 128.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 207.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Шийдвэрлэсэн: Дотоод хяналтыг сайжруулах талаар зөвлөмж өгөв.

Татварын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тус газрын харьяа Баянзүрх дүүрэг, Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" санал дүгнэл өгсөн байна.

Шийдвэрлэсэн: "Хязгаарлалттай дүгнэлт" авсан байгууллагын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох, албан шаардлага өгөв.

#### 1.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ


Сангийн яамнаас авах авлагаар бүртгэсэн 2013 оноос хойш хуримтлагдсан 1,747.9 сая төгрөгийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос төвлөрүүлсэн авлагыг өмнөх онуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар барагдуулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### 1.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Татварын ерөнхий газрын төсвийн орлого болон өөрийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд нарийвчилсан горим гүйцэтгэнэ.

#### 1.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Харьяа 33 байгууллагуудаас 26 нь санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсанаас төрийн аудитын газар 25, хараат бус аудитын компани 1 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, түүврээр 2 байгууллагын санхүүгийн тайланг хамруулж, 5 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүллээ. Аудитаар нийт 5,003.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,559.5 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 20.0 сая төгрөгийн зөрчилд 6 акт, 184.0 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 239.9 сая төгрөгийн зөрчилд 73 зөвлөмж хүргүүлж, зөрчилгүй санал дүгнэлтийг 24, хязгаарлалттай санал дүгнэлтийг 2 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн байна.



Үүнээс Татварын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 180.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад залруулга хийлгэв.

### **1.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Татварын ерөнхий газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна. Үүнээс Нийслэлийн татварын газраас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн хөрөнгийн жагсаалтыг дутуу гаргаж өгснөөс 1 зөвлөмж 50 хувийн биелэлттэй хэрэгжих шатандаа байна.

### **1.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Татварын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангаар нийт зардал 37,634.1 сая төгрөг бөгөөд 2.0 хувиар буюу 752.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

### **1.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид Татварын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Татварын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 1.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

### **1.16 АУДИТЫН ҮР ӨГӨӨЖИЙН БҮРТГЭЛ**

Татварын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тус газрын 2,032.4 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын нэгдсэн системийн програм хангамжийг биет бус хөрөнгөөр бүртгүүлсэн, тухайн тайлант хугацаанд 130.9 сая төгрөгийн зарцуулагдаагүй зардлыг урьдчилж төлсөн зардлаар тусгуулснаар биет бус хөрөнгийн хорогдуулалтыг ашиглалтын хугацаанд нь элэгдүүлж зардалд шингээж, зардлыг үнэн зөв хуваарилж тусгаснаар үр дүн зөв илэрхийлэгдсэнээр, татварын өр төлбөрт хураагдсан нийтийн байранд оршин суугаа тус газрын ажилтнуудтай түрээсийн гэрээ хийснээр өөрийн орлогыг нэмэгдүүлснээр 2,163.3 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж бий болно гэж үзлээ. Кассын ажиллагааны журмыг мөрдөх, хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай, тогтмол явуулснаар хөрөнгөнд тавих хяналт сайжирч, хөрөнгө алга болох шамшигдах эрсдэлээс хамгаалж санхүүгийн бус үр өгөөж бий болно.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

## Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Татварын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

**Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.**



**2.1. Мөнгөн хөрөнгө****Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Анхан шатны баримтын бүрдэлгүй 8.1 сая, 2016 оны анхан шатны баримтаар 0.9 сая төгрөгийн ажил гүйлгээг данс бүртгэлд тусгасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заасантай нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд**

Бэлэн мөнгө шамшигдах, хяналт сулрах.

**ҮАГ-ын зөвлөмж**

Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангах, тайлант оны ажил гүйлгээг бүртгэж байх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж баталгаажуулав.

**2.2. Мөнгөн хөрөнгө****Тэргүүлэх ач холбогдол №2****ҮАГ-ын ажиглалт**

Харилцах данснаас шилжүүлсэн 15.7 сая төгрөгийн бэлэн мөнгийг тогтоосон хязгаараас хэтрүүлэн авч зарцуулсан байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаал "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 6.3-т "Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ... нийт дүн 300.0 мянган төгрөгөөс .... хэтрэхгүй байна." гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд**

Бэлэн мөнгө шамшигдах, хяналт сулрах, зориулалт бус зарцуулах.

**ҮАГ-ын зөвлөмж**

Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг хариуцсан ажилдаа дагаж мөрдөх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж баталгаажуулав.

**2.3. Бараа материал****Тэргүүлэх ач холбогдол №3****ҮАГ-ын ажиглалт**

Үнэт цаасны тооцоог анхан шатны баримттай тулган шалгахад 0.3 сая төгрөгийн зарцуулалтын анхан шатны баримт байхгүй, зарцуулалтын баримтад үнэт цаасны серийн дугаар давхардсан, үнэт цаасны тооллого тооцоог сар бүр хийдэггүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заасантай нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд**

Бараа материал дутагдах, хяналт сулрах;


**ҮАГ-ын зөвлөмж**

Тооллого тооцоог цаг тухайд нь хийж байх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж баталгаажуулав.



**2.4. Бараа материал****Тэргүүлэх ач холбогдол №4****ҮАГ-ын ажиглалт**

Жилийн эцэст тооллого явуулахдаа бараа материалын үлдэгдлийг тоолж, баталгаажуулаагүй, тооллогын комисс тооллогын бүртгэлийг баталгаажуулаагүй, илтгэх хуудас бэлтгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-т *"Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: ... 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/; ...; 72 дугаар зүйлийн 4.-т "Тооллогын комисс дараах үүрэгтэй: ... 2/ тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих; 4/ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;"* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд**

Бараа материал дутагдах, хяналт сулрах.

**ҮАГ-ын зөвлөмж**

Хуулийн дагуу эд хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай гүйцэтгэх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж баталгаажуулав.

**2.5. Дотоод аудит****Тэргүүлэх ач холбогдол №5****ҮАГ-ын ажиглалт**

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,887.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,532.5 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 20.0 сая төгрөгийн зөрчилд акт, 128.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 207.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан *"Дотоод аудитын дүрэм"*-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д *"Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дараах хүрээнд хийнэ, 5.1.3-т "төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал,"* гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

**Эрсдэлүүд**

Бараа материал дутагдах, хяналт сулрах.


**ҮАГ-ын зөвлөмж**

Хуулийн дагуу эд хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай гүйцэтгэх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж баталгаажуулав.



**3. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл****3.1. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>2,912,095.8</b>	<b>3,267,129.6</b>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	512,872.1	525,678.4
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	1,813,308.0	1,789,825.0
УРЬДЧИЛГАА	7а, 7б	-	132,203.1
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	585,915.7	819,423.0
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>15,098,171.9</b>	<b>17,330,964.5</b>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	15,098,171.9	17,330,964.5
Биет хөрөнгө		14,367,062.6	14,862,288.8
Биет бус хөрөнгө	13	731,109.2	2,468,675.7
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>18,010,267.7</b>	<b>20,598,094.1</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>83,071.1</b>	<b>125,290.8</b>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	83,071.1	125,290.8
Өглөг	17а, 17б	83,071.1	125,290.8
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>17,927,196.6</b>	<b>20,472,803.3</b>
Засгийн газрын хувь оролцоо		17,927,196.6	20,472,803.3
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		18,877,901.2	18,877,901.2
Хуримтлагдсан үр дүн		(3,140,577.0)	(584,061.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		2,189,872.4	2,178,963.8
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>18,010,267.7</b>	<b>20,598,094.1</b>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ



**3.2. Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/мянган төгрөг/	
		2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>40,092,301.1</b>	<b>38,094,553.4</b>
ТАТВАРЫН ОРЛОГО		3,385.6	-
Орлогын албан татвар		3,385.6	-
Хувь хүний орлогын албан татвар		3,385.6	-
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1а, 1б</b>	<b>7,637,444.5</b>	<b>3,797,213.2</b>
Нийтлэг татварын бус орлого		7,637,444.5	3,797,213.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		32,451,471.0	34,297,340.3
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2а, 2б</b>	<b>41,209,375.8</b>	<b>37,416,380.1</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>41,209,375.8</b>	<b>37,416,380.1</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>33,807,435.1</b>	<b>34,056,492.2</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		22,540,407.7	22,040,917.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,496,886.8	2,417,365.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,463,160.2	1,329,131.9
Хангамж, бараа материалын зардал		778,483.5	1,114,854.3
Нормативт зардал		433.2	36,902.5
Эд хогшил, урсгал засварын зардал		306,335.9	173,388.6
Томилолт, зочны зардал		164,860.4	150,355.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,107,548.1	4,444,314.2
Бараа үйлчилгээний бусад зардал		1,949,319.4	2,349,262.2
<b>ТАТААС</b>		<b>1,327.6</b>	<b>-</b>
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>7,400,613.0</b>	<b>3,359,887.9</b>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		(1,117,074.7)	678,173.3
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>1,106,187.7</b>	<b>208,423.3</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>		<b>(2,223,262.4)</b>	<b>469,750.0</b>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**3.3. Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>20,147,762.7</b>	-	<b>20,147,762.7</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,754.7	-	5,754.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,153,517.4	-	20,153,517.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(3,058.4)	-	(3,058.4)
Тайлант үеийн үр дүн	(2,223,262.4)	-	(2,223,262.4)
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>17,927,196.6</b>	-	<b>17,927,196.6</b>
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	17,927,196.6	-	17,927,196.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,075,856.7	-	2,075,856.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,003,053.3	-	20,003,053.3
Тайлант үеийн үр дүн	469,750.0	-	469,750.0
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>20,472,803.3</b>	-	<b>20,472,803.3</b>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**3.4. Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/мянган төгрөг/	
		2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>40,490,901.4</b>	<b>78,778,220.7</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		-	<b>6,295.1</b>
Орлогын албан татвар		-	6,295.1
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-	6,295.1
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>3,554,223.4</b>	<b>3,262,299.2</b>
Нийтлэг татварын бус орлого		3,554,223.4	3,262,299.2
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>36,936,678.0</b>	<b>75,509,626.5</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>40,349,155.0</b>	<b>77,106,586.3</b>
УРСГАЛ ЗАРДАЛ		40,349,155.0	77,106,586.3
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>32,408,687.8</b>	<b>32,385,760.6</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		22,411,533.5	21,255,857.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,485,322.9	2,312,682.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,469,187.4	1,335,455.5
Хангамж, бараа материалын зардал		713,913.0	1,001,632.3
Нормативт зардал		74,271.7	58,561.3
Эд хогшил, урсгал засварын зардал		318,100.4	284,988.2
Томилот, зочны зардал		157,886.8	162,113.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,398,824.4	5,556,745.5
Бараа үйлчилгээний бусад зардал		379,647.7	417,723.2
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>7,940,467.2</b>	<b>44,720,825.8</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>		<b>141,746.5</b>	<b>1,671,634.4</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		<b>140,201.5</b>	<b>1,659,007.0</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>140,201.5</b>	<b>1,659,007.0</b>
Дотоод эх үүсвэрээр		140,201.5	1,659,007.0
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>		<b>(140,201.5)</b>	<b>(1,659,007.0)</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>		<b>1,544.9</b>	<b>12,627.4</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		511,327.2	512,872.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		512,872.1	525,678.4

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**3.5. Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,143,415.9	31,850,170.5	293,245.4	99.1
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>30,610,415.9</b>	<b>30,341,427.5</b>	<b>268,988.4</b>	<b>99.1</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>28,908,175.9</b>	<b>28,734,944.7</b>	<b>173,231.2</b>	<b>99.4</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>20,039,506.0</b>	<b>19,991,737.4</b>	<b>47,768.6</b>	<b>99.8</b>
Үндсэн цалин	13,288,443.9	14,055,911.6	(767,467.7)	105.8
Нэмэгдэл	3,436,508.7	2,930,987.2	505,521.5	85.3
Унаа хоолны хөнгөлөлт	1,073,304.2	1,060,782.8	12,521.4	98.8
Урамшуулал	2,241,249.2	1,944,055.7	297,193.5	86.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,240,757.5	2,224,979.9	15,777.6	99.3
Тэтгэврийн даатгал	1,439,043.8	1,764,316.4	(325,272.6)	122.6
Тэтгэмжийн даатгал	164,130.4	100,307.4	63,823.0	61.1
ҮОМШӨ-ний даатгал	196,637.0	105,735.3	90,901.7	53.8
Ажилгүйдлийн даатгал	40,094.1	26,243.2	13,850.9	65.4
<b>Эрүүл мэндийн даатгал</b>	<b>400,852.2</b>	<b>228,377.6</b>	<b>172,474.6</b>	<b>57.0</b>
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,403,397.7	1,331,755.5	71,642.2	94.9
Гэрэл, цахилгаан	193,854.5	168,814.0	25,040.5	87.1
Түлш, халаалт	432,657.2	402,545.9	30,111.3	93.0
Цэвэр, бохир ус	74,817.2	57,178.2	17,639.0	76.4
<b>Байрны түрээс</b>	<b>702,068.8</b>	<b>703,217.3</b>	<b>(1,148.5)</b>	<b>100.2</b>
Хангамж, бараа материалын зардал	871,573.8	862,916.2	8,657.6	99.0
Бичиг хэрэг	200,513.4	193,797.2	6,716.2	96.6
Тээвэр, шатахуун	141,913.9	160,578.7	(18,664.8)	113.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	423,834.3	336,996.6	86,837.7	79.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	28,503.3	16,115.2	12,388.1	56.5
<b>Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс</b>	<b>76,808.9</b>	<b>155,428.5</b>	<b>(78,619.6)</b>	<b>202.4</b>
Нормативт зардал	57,952.9	57,921.3	31.6	100.0
<b>Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл</b>	<b>1,447.9</b>	<b>1,483.3</b>	<b>(35.4)</b>	<b>102.4</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	56,505.0	56,438.0	67.0	99.9
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>125,615.0</b>	<b>124,205.8</b>	<b>1,409.2</b>	<b>98.9</b>
Багаж, техник, хэрэгсэл	33,666.7	34,502.0	(835.3)	102.5
Урсгал засвар	91,948.3	89,703.8	2,244.5	97.6
Томилолт, зочны зардал	156,231.2	148,276.9	7,954.3	94.9
Дотоод албан томилолт	156,231.2	148,276.9	7,954.3	94.9
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,725,960.8</b>	<b>3,714,126.1</b>	<b>11,834.7</b>	<b>99.7</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,015,804.9	1,009,668.6	6,136.3	99.4

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАА ДҮГНЭЭТ

<b>Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох</b>	<b>6,748.0</b>	<b>4,657.1</b>	<b>2,090.9</b>	<b>69.0</b>
Даатгалын үйлчилгээ	23,837.0	22,318.5	1,518.5	93.6
Тээврийн хэрэгслийн татвар	5,152.6	4,083.3	1,069.3	79.2
Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,416.4	2,104.7	311.7	87.1
<b>Мэдээлэл, технологийн үйлчилгээ</b>	<b>517,009.8</b>	<b>517,009.7</b>	<b>0.1</b>	<b>100.0</b>
Газрын төлбөр	2,432.2	1,724.2	708.0	70.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,152,559.9	2,152,559.9	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	287,181.0	279,025.6	8,155.4	97.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	287,181.0	279,025.6	8,155.4	97.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,702,240.0	1,606,482.8	95,757.2	94.4
Бусад урсгал шилжүүлэг	1,702,240.0	1,606,482.8	95,757.2	94.4
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	127,251.4	127,147.7	103.7	99.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,028,088.6	939,187.7	88,900.9	91.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	546,900.0	540,147.4	6,752.6	98.8
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,533,000.0</b>	<b>1,508,743.0</b>	<b>24,257.0</b>	<b>98.4</b>
Барилга байгууламж	33,000.0	33,000.0	-	100.0
Тоног төхөөрөмж	1,500,000.0	1,475,743.0	24,257.0	98.4
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>32,143,415.9</b>	<b>31,871,141.2</b>	<b>272,274.7</b>	<b>99.2</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>30,077,363.0</b>	<b>29,799,020.4</b>	<b>278,342.6</b>	<b>99.1</b>
Улсын төсвөөс санхүүжих	30,077,363.0	29,799,020.4	278,342.6	99.1
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2,066,052.9</b>	<b>2,072,120.8</b>	<b>(6,067.9)</b>	<b>100.3</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,766,302.9	1,949,552.1	(183,249.2)	110.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	299,750.0	122,568.7	177,181.3	40.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	509,387.9	(509,387.9)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	520,439.5	(520,439.5)	-

